

ХҮРЭЭЛЭН 40 НАС ХҮРЛЭЭ

*Д.Золбоо**

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн энэ оны 6 дугаар сард 40 жилийнхээ ойг тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ жилийн хувьд зөвхөн баяр ёслолын төдийгүй эрдэм судлал, олон улсын эрдэм шинжилгээний хамтарсан форумтай хамтатган зохион байгуулснаараа онцлог болов.

Уг олон улсын эрдмийн анхдугаар форум нь “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” сэдвийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Төрийн ордоны “Б” танхимд 2008 оны 6 дугаар сарын 16-17-ны өдөр болов.

БСШУЯ, Гадаад хэргийн Яам, Шинжлэх Ухааны Академи, Олон Улс Судлалын Хүрээлэнгээс эрхлэн зохион байгуулсан уг форумын үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, БСШУ-ны сайд Н.Болормаа нээж, Монгол Улсын Ерөнхий сайд Санжаагийн Баярын мэндчилгээг дэвшүүлсэн юм.

Түүнчлэн Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Баатарын Чадраа, ойн арга хэмжээний хүндэт зочдын нэг ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн захирал, профессор Р.Б.Рыбаков нар мөн мэндчилгээ дэвшүүлсэн бөгөөд БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази Номхон далайн судлалын хүрээлэнгийн захирал, профессор Жан Юйянь нар оролцсон юм.

Форумын үндсэн илтгэлийг ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Батболдын Энхтүвшин “Монгол Улсын хөгжилд ОХУ, БНХАУ-ын хүчин зүйлс” сэдвээр тавьсан нь судлаачдыг сонирхлыг ихээхэн татсан байна.

Хоёр өдрийн турш үргэлжилсэн форумын бусад дагалдах илтгэлүүдийг илтгэгчдийн хамт нэрлэвэл:

- ГХЯ-ны Хөрш орнуудын газрын захирал Х.Аюурзана, зөвлөх Л.Баттулга “Монгол, Орос, Хятадын харилцаа: төлөв байдал”
- ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Монгол судлалын секторын ЭШТА, доктор /Sc.D/, профессор Г.С.Яскина “Орос, Монгол, Хятад, Энэтхэг: хамтын ажиллагааны байдал ба хэтийн төлөв”
- ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын шинжлэх ухааны Төвийн тэргүүлэгчдийн дарга, Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэнгийн захирал, ОХУ-ын ШУА-ийн сурвалжлагч-гишүүн, профессор Базаров Б.В., магистр

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

- Базаров В.Б. “Монголын эрдэс баялгийн нөөц: Дотоод Ази дахь геополитикийн хүчин зүйл”
- БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази Номхон далайн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, /Ph.D/, профессор Пяо Жянь-И “Зүүн Хойд Азийн олон улсын харилцаа ба Хятад-Монголын стратегийн хамтын ажиллагаа”
 - МУИС-ийн Эдийн Засгийн сургуулийн тэргүүлэх профессор, академич Т.Дорж, ОУСХ-ийн секторын эрхлэгч, доктор /Sc.D/, профессор Ц.Баатар “Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал ба ирээдүйн хандлага”
 - ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Монгол судлалын секторын эрхлэгч, /Sc.D/, профессор В.В.Грайворонский “Орос, Монгол, Хятадын худалдаа-эдийн засгийн харилцаа: үндсэн хандлага, хэтийн төлөв”
 - МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн тэргүүлэх профессор, /Sc.D/, Д.Дагвадорж, тэнхимийн эрхлэгч, /Ph.D/, профессор Б.Даваасүрэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилт, хэтийн төлөв”
 - ГХЯ-ны Газрын захирал /Sc.D/ Ц.Батбаяр, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, /Ph.D/ Д.Шүрхүү “Хөгжингүй тээврийн дэд бүтэц-Хойд Ази дахь интеграцийг бэхжүүлэх чухал хүчин зүйл”
 - Хятадын Нийгмийн ШУА-ийн Ази, Номхон далайн судлалын хүрээлэнгийн захирал, профессор Жан Юй Янь “Газрын тосны үнийн хэлбэлзэл олон улсын эрчим хүчний тэнцвэртэй байдалд нөлөөлөх нь”
 - ШУА-ийн ОУСХ-ийн Орос судлалын секторын эрхлэгч, /Sc.D/, профессор О.Батсайхан, /Ph.D/ А.Нямдолжин “Монгол, Оросын харилцаа: уламжлал, шинэчлэл”
 - ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Монгол судлалын секторын ЭШАА, /Ph.D/ Е.В.Бойкова “Орос ба Монгол: XXI зуун дахь түншлэлийн харилцаа”
 - Хятадын Нийгмийн ШУА-ийн Ази Номхон далайн судлалын хүрээлэнгийн профессор Чэнь Шань “Хятад-Монгол-Оросын бүс нутаг дахь аж үйлдвэрийн тогтолцооны стратегийн зохицуулалт”
 - ГХЯ-ны Газрын дэд захирал, /Sc.D/ Г.Төмөрчулуун “Монгол Улсын Азийн бодлого”
 - ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Монгол судлалын секторын ЭШТА, /Sc.D/ М.И.Гольман “Монголын

- үндэсний аюулгүй байдлын асуудалд өрнөдийн эрдэмтдийн хийсэн дүн шинжилгээ”
- ОУСХ-ийн захирал, /Sc.D/, профессор Л.Хайсандай, /Ph.D/ Л.Оюунгэрэл “Хоёр хөрш ба Монголын эдийн засгийн аюулгүй байдлын асуудлууд”
 - БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн захирал, профессор Түмэнцэцэг “Хятад-Орос-Монголын хилийн худалдааны хөгжлийн тулгамдсан асуудал ба өнөөгийн байдал”
 - МУИС-ийн Олон Улсын Харилцааны дээд сургуулийн захирал, /Ph.D/ Н.Алтанцэцэг “Монгол Улсын гадаад бодлогын талаарх Орос, Хятадын эрдэмтдийн судалгаа”
 - ОХУ-ын Халимагийн Нийгмийн ухааны хүрээлэнгийн захирал, доктор, профессор Н.Г.Очирова “Халимаг ба Монгол: хамтын ажиллагааны түүх ба хэтийн төлөв”
 - ОХУ-ын Ар Байгалийн Хүмүүнлэгийн Боловсролын Их Сургуулийн проректор В.В.Кузнецов, Ар Байгалийн Хүмүүнлэгийн Боловсролын Их сургуулийн Олон Улс Судлалын Төвийн захирал Г.Г.Васильев “Глобалчлалын нөхцөлд Орос-Монголын хамтын ажиллагааны тулгамдсан асуудал”
 - БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн дэд профессор, докторант Н.Улаан-Од “БНХАУ болон Монгол Улсын хоёр талын харилцааны тухай өгүүлэх нь” зэрэг болно.

Хүрээлэнгийн 40 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн хурал 2008 оны 6 дугаар сарын 18-ны өдөр ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн II байрны хурлын танхимд болсон бөгөөд төр захиргааны болон хамтран ажилладаг олон байгууллага баяр хүргэж мэндчилгээ ирүүлсэн байна. Тус хүрээлэнгийн эрдмийн хамт олонд олон байгууллага хувь хүн шагнал гардуулсан, тухайлбал эрдэм шинжилгээний ахлах ажилтан А.Буянтөгс “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” цол тэмдгээр энгэрээ мялаасан бол эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Шүрхүү, доктор Ц.Баатар, О.Батсайхан, Л.Бэгзжав, референт Б.Чимгээ, нягтлан бодогч Б.Ганчимэг нарыг яамдын хүндэт жуух бичгээр шагнасан юм. Мөн ойн хүрээнд хүрээлэнгийн тухай анхны өнгөт хэвлэмэл танилцуулга гаргаж, албан ёсны веб хуудас зэргийг нээснээс гадна хүрээлэнгийн товч түүх болох товхимолыг “Олон улс судлал 40 жил” нэртэйгээр түүхэн гэрэл зураг, ахмад эрдэмтдийн дурсамжийн хамт эмхтгэн хэвлүүлэн гаргав.